



“МОНГОЛ БАЗАЛТ” ХК-ИЙН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ ХУРЛЫН ТЭМДЭГЛЭЛ

2026 оны 04-р сарын 30-ны өдөр

Улаанбаатар хот

Хурал: 2026 оны 04 сарын 30-ны өдрийн 10.00 цагт Сүхбаатар дүүрэг, 1-р хороо, Сүхбаатарын талбай хаягт байрлах Монголын хөрөнгийн биржийн мэдээллийн танхимд болсон.

Хурлын дарга: Компанийн төлөөлөн удирдах зөвлөлийн 2026 оны 03 сарын 21-ний өдрийн Хувьцаа эзэмшигчдийн хурал зарлан хуралдуулах тухай 06 дугаартай тогтоолоор хурлын даргаар ТУЗ-ийн хараат бус гишүүн Пүрэвсүх овогтой Нямдоржийг томилсон.

Хурлын ирц: Ирц бүртгэл, санал хураалтыг ТУЗ-ийн 2026 оны 03 сарын 21-ний өдрийн 06 дугаар тогтоолоор томилогдсон тооллогын комиссын дарга Н.Сугарсүрэн, гишүүд Б.Уранбилэг, Б.Амаржаргал нар явуулсан бөгөөд хурлын ирцийн дэлгэрэнгүй жагсаалтыг тэмдэглэлд хавсаргав. Хуралд нийт 39,533,738 ширхэг хувьцаа эзэмшиж буй саналын эрхтэй 37 хувьцаа эзэмшигч өөрөө биечлэн, эцэг эх хувьд болон итгэмжлэлийн дагуу оролцсон байна.

Хэлэлцэх асуудал:

1. Монгол базальт ХК-ийн 2025 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаар Төлөөлөн удирдах зөвлөлийн дүгнэлтийг батлах тухай
2. Монгол базальт ХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүдийг сонгох тухай

Хурлын дарга П.Нямдорж: Сайн байцгаана уу. Цаг заваа зориулан хуралдаа ирсэн та бүхэндээ баярлалаа. Энэ удаагийн хувьцаа эзэмшигчдийн хуралд хувьцаа эзэмшигчидээс гадна Төлөөлөн удирдах зөвлөлийн хараат бус гишүүн Ш.Энхтөр, Ч.Зоригтбаатар, П.Нямдорж, ердийн гишүүн Л.Ариунболд, Б.Шаравсамбуу, Г.Ганзориг, П.Сайнбилэг нар, Гүйцэтгэх захирал А.Энхгэрэл, Хөндлөнгийн аудит хийж дүгнэлт гаргасан “Нексия Глобал Монголиа Аудит” ХХК-ийн захирал Булган, аудитор Дэлгэрмаа нар хүрэлцэн ирсэн байна. Тооллогын комиссын даргыг хурлын ирц, тооллогын комиссын тогтоолыг танилцуулна уу хэмээн урьж байна.

Н.Сугарсүрэн: Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын тооллогын комиссын тогтоол 2026.04.30-ны өдрийн 01 дугаартай Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын ирц болон хурал хүчин төгөлдөр болсон тухай тогтоолыг танилцуулья.

Тогтоолд: “Монгол базальт” ХК-ийн Хувьцаа эзэмшигчдийн дэлгэрэнгүй судалгаанд багтсан нийт 56,417,000 ширхэг хувьцаа эзэмшдэг 2542 хувьцаа эзэмшигчдээс 37 хувьцаа эзэмшигчийн 39,533,738 ширхэг хувьцаа буюу нийт саналын эрхтэй хувьцааны 70.07% болж Хувьцаа Эзэмшигчдийн Хурал хуралдуулах ирц бүрдэж, хурал хүчин төгөлдөр болсныг зөвшөөрч баталсугай.

Хурлын дарга П.Нямдорж: Хувьцаа эзэмшигчдийн хурлаар хэлэлцэх асуудал болон Компанийн 2025 оны Үйл ажиллагааны болон санхүүгийн тайланг нэгтгэн Хувьцаа эзэмшигчдийн хурлын материал бэлтгэн хэвлүүлж брокер, диллерийн компаниар дамжуулан хүргүүлсэн ба компанийн цахим хуудас

байршуулсан байсан. Хувьцаа эзэмшигчдийн хурал зарлан хуралдуулах тухай ТУЗ-ийн тогтоолоор батлагдсан хэлэлцэх асуудал, дэгийн дагуу хурлаа үргэлжлүүлье.

Дэгийг уншиж танилцуулав.

Ингээд компанийн 2025 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайланг танилцуулна уу хэмээн Гүйцэтгэх захирал А.Энхгэрэлийг индэрт урьж байна.

Гүйцэтгэх захирал А.Энхгэрэл: Өглөөний мэнд. 2026 оны Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хуралдаа хүрэлцэн ирсэн та бүхэндээ баярлалаа. Монгол базальт ХК нь 2025 онд бизнес төлөвлөгөөний хэрэгжилтийг хангаж, эрэлт нийлүүлэлтийн тэнцвэржүүлэх бодлогын хүрээнд нийт 2165 тонн базальт чулуун хөвөн бүтээгдэхүүн үйлдвэрлэж зах зээлд нийлүүлсэн ба 9.25 тэрбум төгрөгийн борлуулалтын орлоготой 147 сая төгрөгийн цэвэр ашигтай ажилласан байна. Үйлдвэрлэлийн дамжлагын тоног төхөөрөмжийн шинэчлэлт, зүгшрүүлэлтийн ажлыг хийж дуусгаснаар технологийн алдагдалыг бууруулж, бүтээгдэхүүний өөрийн өртгийг боломжит хэмжээнд бууруулсан байна. Мөн шүршдэг базальт, урсдаг базальт бүтээгдэхүүний стандартын баримт бичгүүдийг тус тус шинээр батлуулсан. Хүний нөөц ба аюулгүй ажиллагааны хувьд тайлант хугацаанд үйлдвэрлэлийн осолгүй ажилласан, ISO нэгдсэн менежментийн тогтолцооны 9001, 45001, 14001 стандартуудын баталгаажуулалтын аудитыг амжилттай хамгаалсан байна. Инженер техникийн ажилтнуудын мэргэжил дээшлүүлэх, туршлага солилцох сургалтуудад үе шаттай хамруулснаар ажиллах хүчний болон түлхүүр ажилтнуудын тогтвор суурьшлыг хадгалаж ажилласан ба хүний нөөцийн эргэц 2.5 хувь байгаа нь өмнөх жилүүдээс илүү сайжирсан байна.

Байгаль орчны үзүүлэлт буюу ESG хувьд үйлдвэрлэлийн үйл ажиллагааны байгаль /орчинд үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах ажлуудыг жил бүр хийж, хэрэгжүүлж байсан ба усны хэрэглээг 31 хувь, эрчим хүчний хэрэглээг 20 хувь бууруулж чадсан. Энэ нь үйлдвэрлэлийн үйл ажиллагааны өртөг, зардлыг бууруулахад эерэгээр нөлөөлсөн гэж үзэж байгаа. 2025 онд байгаль орчны нөлөөллийг бууруулах дотоод журам боловсруулж батлуулах, нийт ажилтнуудын сургалт зааварчилгааг тогтмол зохион байгуулж ажилласан. Өнгөрсөн онд үнэт цаасны зах зээлийн арилжаанд компанийн хувьцааны дээд ханш 209.9 төгрөг, доод ханш 161.03 төгрөг байсан бол 2025 оны хаалтын ханшаар 208.98 төгрөгт хүрсэн байна. 2024 оны цэвэр ашигаас нэгж хувьцаанд 2.42 төгрөгийн ногдол ашиг тараасан бол 2025 оны цэвэр ашгаас 2.61 төгрөгийн ногдол ашиг тараасан болно. Компанийн цэвэр ашигтай ажилласан л бол жил бүр ногдол ашиг тараах бодлогын хүрээнд шийдвэрийг гаргаж нийт цэвэр ашгийн 99.5 хувийг тараасан. 2025 оны 1, 2 сар - байшин сууцаа дахин дулаалах замаар утааг бууруулах талаар мэдээлэл хүргэх зорилго бүхий “Утааг дулаалж ялна” сэдэвт сургалтуудыг СХД-ийн 4, 5, 7, 10, 26, 33 хороодууд зохион байгуулсан ба нийт 571 иргэнийг хамруулсан. 2025 оны 3 сар - Барилга угсралтын компани, бригадууд, төсөл хэрэгжүүлэгчид болон салбарын мэргэжилтэн нарын дунд термопассив хаус бүтэц элемент угсрах зааварчилгаа болон технологийн зөвшилцөх уулзалтыг зохион байгуулав. 2025 оны 4 сар- Дархан хотын иргэдэд пассив панел хийц технологи танилцуулах нээлттэй өдөрлөг зохион байгуулав. 2025 оны 8 -12 сар: “Дулаанбаатар” аяны хүрээнд Монгол Базальт ХК нь УИХ-ын гишүүн Г.Лувсанжамц, түүний ажлын хэсэг болон нийслэлийн 6 дүүргийн Засаг дарга, холбогдох албан тушаалтнуудтай хамтран 2000 гаруй иргэдэд 14 удаагийн дулаалгын сургалт, зөвлөгөө арга хэмжээг зохион байгууллаа. Мөн Гаалийн ерөнхий газартай ххамтран Оюуны өмчийн бүртгэлтэй бараа бүтээгдэхүүний сургалт зохион байгуулж, барилгын материалын хууль зөрчсөн импортын тухай сургалтыг хийсэн байна.

ХЭХ-д дэлгэцээр танилцуулах РРТ-г тэмдэглэлд хавсаргасан ба дэлгэцийн харагдах байдал товч:



ТУЗ-ийн хараат бус гишүүн Ш.Энхтөр: Та бүхэнд энэ өдрийн амар амгаланг эрье. Монгол базальт ХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөл нь 2026 оны 03 сарын 05-ны өдөр хуралдаад тус компанийн 2025 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаар дүгнэлт гаргаж, өнөөдрийн хувьцаа эзэмшигчдийн хурлаар хэлэлцүүлэхээр шийдвэрлэсэн байгаа. Хурлын материалд дүгнэлт бүрэн эхээр авагдсан байгааг уншиж танилцуулъя.

МОНГОЛ БАЗАЛТ ХК
ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ДҮГНЭЛТ
(2025 оны үйл ажиллагаа болон санхүүгийн тайлангийн талаар)

Монгол базальт ХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөл нь компанийн 2025 оны үйл ажиллагаа болон санхүүгийн тайланг холбогдох хууль тогтоомж, компанийн дүрэм болон засаглалын зарчмын хүрээнд хянан хэлэлцэж, хувьцаа эзэмшигчдэд дараах дүгнэлтийг танилцуулж байна.

2025 онд компанийн борлуулалтын орлого 9.26 тэрбум төгрөгт хүрч, өмнөх оны 12.28 тэрбум төгрөгөөс 24.6 хувиар буурсан үзүүлэлттэй байна. Борлуулалтын бууралтад барилгын салбарын эрэлт саарах, шинэ төсөл, барилгажилтын ажил буурах, мөнгөний бодлогын хатуу нөхцөл үргэлжилж бодлогын хүү өндөр түвшинд хадгалагдсан, инфляцын дарамт, иргэдийн худалдан авах чадварын уналт болон дулаалгын материалын зах зээлд өрсөлдөөн нэмэгдэх зэрэг макро болон салбарын хүчин зүйлс голлон нөлөөлсөн байна.

Гэсэн хэдий ч компанийн зүгээс түүхий эдийн худалдан авалтын оновчтой менежмент, үйлдвэрлэлийн үр ашгийг нэмэгдүүлэх, үйл ажиллагааны зардлын сахилга батыг сайжруулах чиглэлээр тодорхой арга хэмжээнүүдийг авч хэрэгжүүлсний үр дүнд нэгж борлуулалт тутамд ноогдох үйлдвэрлэлийн өртөг 73.1 хувиас 72.3 хувь болж 0.8 пунктээр сайжирсан бөгөөд уг сайжрал нь ойролцоогоор 80 сая төгрөгийн ашиг хамгаалсан байна. Үүний нөлөөгөөр нийт ашгийн хувь 26.9 хувиас 27.7 хувь болж сайжирсан бөгөөд тайлант үеийн цэвэр ашиг 147.4 сая төгрөг байгаа нь өмнөх оны түвшинд хадгалагдан эерэг гүйцэтгэл үзүүлэв.

Төлөөлөн удирдах зөвлөл нь тайлант хугацаанд компанийн үйл ажиллагаанд нөлөөлж болзошгүй зах зээлийн, макро эдийн засгийн, санхүүгийн болон үйл ажиллагааны эрсдэлүүдийг үнэлэхэд эдгээр эрсдэлүүд нь ерөнхийдөө хяналттай түвшинд байсан бөгөөд компанийн удирдлагаас авч хэрэгжүүлсэн арга хэмжээ нь тогтвортой байдлыг хадгалахад чиглэгдсэн гэж үзэж болно.

Цаашид компанийн хувьд дотоодын зах зээл дэх борлуулалтыг сэргээх, төрөлжүүлэх, экспортын зах зээлийг хөгжүүлэх, зардлын үр ашгийг нэмэгдүүлэх бодлогыг үргэлжлүүлэх, ногоон барилга болон эрчим хүчний хэмнэлттэй бүтээгдэхүүний хөгжүүлэлтийг эрчимжүүлэх, эрсдэлийн удирдлагын тогтолцоог улам бэхжүүлэх шаардлагатай гэж Төлөөлөн удирдах зөвлөл үзэж байна.

Иймд Төлөөлөн удирдах зөвлөл нь Монгол базальт ХК нь 2025 онд зах зээлийн тааламжгүй нөхцөлд үйл ажиллагаа явуулсан хэдий ч зардлын удирдлага, үйлдвэрлэлийн үр ашгийг сайжруулах арга хэмжээг үр дүнтэй хэрэгжүүлснээр ашигт ажиллагааны түвшнийг хадгалж чадсан нь компанийн тогтвортой байдлын илэрхийлэл болсон гэж дүгнэж байна.

ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛ

Хурлын дарга П.Нямдорж: Бидний дараагийн хэлэлцэх асуудал бол Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүдийг сонгох тухай юм. Та бүхэнд хүргэсэн хурлын материалд ТУЗ-ийн гишүүнд нэр дэвшигчдийн дэлгэрэнгүй мэдээллийг хавсаргасан байгаа болно гээд дэлгэцээр танилцуулав. Үүнд:

[illegible][illegible]



БАДРАХАН ШАРАФМАММДОВ

Күтүлгү: 1945-жылдан күркөтүрүсү

ТӨЛӨПӨН УНДУРАЛ ЗАСАВЫНН СРДЫН ГИШТӨД НЭР ДИМШЭГ-ӨД

Мамлекеттик улусун багытта административ
Мамлекеттик Заманбап

Бөлүмчөлөрү:
1973-жылдан баштап парламенттин депутаты
1975-жылдан улус административде кызматта
Мамлекеттик Заманбап, административдик кызматтагы улус административде кызматта
Мамлекеттик Заманбап, административдик кызматтагы улус административде кызматта

Амалга ашырган багыттары:
1973-1975-жылдары Мамлекеттик Заманбап, административдик кызматтагы улус административде кызматта
1975-1979-жылдары Мамлекеттик Заманбап, административдик кызматтагы улус административде кызматта
1979-1984-жылдары Мамлекеттик Заманбап, административдик кызматтагы улус административде кызматта
1984-1987-жылдары Мамлекеттик Заманбап, административдик кызматтагы улус административде кызматта
1987-1991-жылдары Мамлекеттик Заманбап, административдик кызматтагы улус административде кызматта
1991-1994-жылдары Мамлекеттик Заманбап, административдик кызматтагы улус административде кызматта
1994-1998-жылдары Мамлекеттик Заманбап, административдик кызматтагы улус административде кызматта
1998-1999-жылдары Мамлекеттик Заманбап, административдик кызматтагы улус административде кызматта
1999-2003-жылдары Мамлекеттик Заманбап, административдик кызматтагы улус административде кызматта
2003-2004-жылдары Мамлекеттик Заманбап, административдик кызматтагы улус административде кызматта
2004-2008-жылдары Мамлекеттик Заманбап, административдик кызматтагы улус административде кызматта
2008-2009-жылдары Мамлекеттик Заманбап, административдик кызматтагы улус административде кызматта



БААТАР
BAATAR

ТӨЛӨӨЛӨН ҮНДЭХАД ЗӨВЛӨӨЛӨЙН ХАРААТ БҮС ГҮШЛЭНД ХӨР ДЭВШИМЧД

Мэргэжил: Санхүү Цогцолгоа

Бэлэнхэр:
2004-2008 он Санхүү Зүйн Засгийн Их сургууль - Санхүү хариуцаагч

Ажил эрхлэлт ба туршлага:
2008-2009 он "БайрСХ ҮНД" ХХК - Хэрэгжилт-чдийн амьс, Засагч
2009-2020 он "БайрСХ ҮНД" ХХК - Хэрэгжилт-чдийн амьс, ажил бүрэлдэ
2021-2022 он "БайрСХ ҮНД" ХХК - Хэрэгжилт-чдийн амьс Мөнгөтөр
2022-2023 он "БайрСХ ҮНД" ХХК - Хэрэгжилт-чдийн амьс, Засагч
2023-2025 он "БайрСХ ҮНД" ХХК - Хэрэгжилт-чдийн амьс, Засагч
2025 оноос "БайрСХ ҮНД" ХХК - Гадаад хэрэгжилт-чдийн амьс, Засагч

Хүндэтгэл / Хүндэтгэгчдийн үнэмлэх

[illegible]



ТӨГӨӨЛИН ҮНДЭХЛЭЙН ХАРААТ БҮС ГҮШИГНД НЭР ДЭВШИЙНД

Мэргэжил: Зар зүйн, Бэлчээний урьдчилгаа

Бэлчээр:
 1987-1992 он -Бэлчээний Цэцэрлэг, Комсомольск дотун С.дүрвүүр-Комсомольск (Тэр)
 1993-1997 он МУУС, Зууны, Уул Ир Сургууль- Зар зүйн
 2000-2004 он СЗУП- Бэлчээний Хүдэрлэлт, Бэлчээнийхэн удирдлагын мэргэжл

Ажил хэргийн ба туршлагыг:
 1987-2008 он Худалдаа Хөгжлийн Банк, Күүлүн, Ахуйн үйлдвэр, Газар хөдөлгөөнд
 2009-2013 онд Хадгалуу Банкны Гүйцэтгэл газрын захирал
 2014-2017 онд "Чөлөөтэй мөхөөдөгч" ХХК-ийн захирал, мөхөөдөгч
 2018-2019 онд Хүмүүн Банкны Хүмүүнлэг, дэмжлэгний газрын захирал
 2020 оноос" Мөхөөдөгч Банкны захирал газрын захирал
 2018 оноос" Мөхөөдөгч Банкны" 88-ийн ТХЗ-ийн захирал Тэр гүйцэтгэл

ШАРВАБМБУЙУР ЭНХБӨР



М.БАТБАЯР
BATTAYAR MUKHAYAR

Хүснэгт 1. Хүний нэр, хаяг, үйлдвэр

ТӨГӨӨЛӨӨЛӨН ХҮҮДИЙН ЗӨВЛӨӨЛӨЛӨН ХАРАЛ БҮС ГЭШЛЭХН НЭР ДӨШӨМӨЧӨД



Мэргэжлээс: Бизнесийн удирдлага

Бэлгэглэл:
1996-2000 он Шонхон донд суугаагүй - багш
2008-2009 он Хөдөөдөгч он-ашигтай - багш

Ажил хэрлэлт ба туршлага:
2008 он Наран-нэр өргөдөг - ХХК - багшад
2009-2010 он MINTS KOK - бүтээгч
2013-2016 он Гагурдуг гүйцэтгэх - Агаар бүтээгч
2015 он Мангатайн Наран-нэр бүтээгч - ТӨХК - Мэргэжлээс өргөдөгч
2022-2022 "Нийслэл амьтантай" ТӨХК -ийн донд багшад
2022-2024 "Нийслэл амьтантай" ТӨХК -ийн гүйцэтгэх захирал
2024 онд Мангатайн Наран-нэр бүтээгч Бизнесийн хөгжлийн хөдөлгөөнийг өргөдөгч
2021 онд "Мангатайн багш" ХХК-ийн ТЭГ-ийн хөрөөт гүйцэтгэх

ЛҮРЭВСҮХ НЯМДОРЖ

Хурлын дарга П.Нямдорж:

Та бүхэн нэр дэвшигчдээс асуулт асууж болно. Нэр дэвшигчдийн талаар Компанийн тухай хууль, компанийн дүрэм болон нэр дэвшүүлэх хорооны үйл ажиллагааны журмын дагуу ТУЗ-ийн дэргэдэх нэр дэвшүүлэх хорооноос дүгнэлт гаргасан болно. *Дүгнэлтийг танилцуулав.*

BASALTWOOL
MONGOL BASALT JSC

МОНГОЛ БАЗАЛТ ХК-ийн төлөөлөн удирдах зөвлөлийн дэргэдэх нэр дэвшүүлэх хорооны дүгнэлт

1. ҮНДЭСЛЭЛ

Монгол базальт ХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн дэргэдх Нэр дэвшүүлэх хороо нь Компанийн тухай хууль, компанийн дүрэм, Компанийн засаглалын кодекс болон Нэр дэвшүүлэх хорооны үйл ажиллагааны журмын дагуу Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүнд нэр дэвшигчдийн материалыг хянан хэлэлцж, дараах дүгнэлтийг гаргав.

3. ХАРААТ БҮС БАЙДАЛ, НИЙЦЛИЙН ҮНЭЛГЭЭ

Нэр дэвшүүлэх хороо нь нэр дэвшигч бүрийн хараат бүс байдал, ашиг сонирхолын зөрчил үүсэх нөхцөлтийг үнэлж, хараат бүс байдал нэр дэвшигчид үзэгдэхгүйгээр (Ш.Халсан, Б.Очинов, П.Нямдорж нар нь Компанийн тухай хуулийн 59 дүгээр зүйлийн 79.1-д заасан болон Компанийн засаглалын кодекс заасан хараат бүс байдалын шалгуурыг хангаж байна. Нэр дэвшигчид нь компанийн үйл ажиллагаанд ашиг сонирхолын зөрчил үүсгэх нөхцөлгүй. Ес зүйн болон маргажигч ур чадварын шаардлагад нийцж байна.

2. НЭР ДЭВШИГЧДИЙН ТАЛААРХ МЭДЭЭЛЭЛ

ТУЗ-ийн гишүүнд нэр дэвшигчид нь холбогдох хууль тогтоомжид заасан шалгуур шаардлагыг хангасан бөгөөд тэдгээрийн боловсрол, мэргэжил, ажлын туршлага, ур чадвар нь компанийн үйл ажиллагааны онцлог, стратегийн зорилттой нийцж байна. Нэр дэвшигчид нь:

- Удирдлага, санхүү, инженер, техник, бизнесийн салбарт ажиллаж байсан туршлагатай
- Компанийн засаглал, эрсдэлийн удирдлага, стратегийн шийдвэр гаргалтын талаар мэдлэгтэй
- Ес зүйн нэр хүнд, маргажигчын хариуцалтын шаардлагыг бүрэн хангаж байна

4. ЧАДВАР, УР ЧАДВАРЫН ҮНЭЛГЭЭ

ТУЗ-ийн нийт бүрэлдвэрүүдийг хувиар дараах ур чадвар, туршлагын тэмцвэрийг хангах боломжтой гэж Нэр дэвшүүлэх хороо үзэж:

- Стратеги, бодлого боловсруулах чадвар
 - Санхүү, аудит, эрсдэлийн удирдлагын мэдлэг
 - Үйлдвэрлэл, инженерийн-техник салбарын ойлголт
 - Олон улсын зах зээл, бизнесийн туршлага
- Засгал, ёс зүйн ойлголт

Санал хураах хугацаа 15 минут байгаа, та бүхэн санал тоолох хугацаанд та бүхнийг цай, кофе өглөөний зуушаар дайлож байгаа юм. Саналын хуудсаа тооллогын комисст хураалгаарай.

Хурлын дарга П.Нямдорж: Санал тоолох хугацаанд уламжлал ёсоор хувьцаа эзэмшигч нарынхаа дундаас азтангаа тодруулья. Та бүхэн ирцээ бүртгүүлээд орж ирэхдээ сугалааны хайрцагт утасны дугаараа бичиж хийсэн байгаа. Энд байгаа хувьцаа эзэмшигч нараасаа азтангаа тодруулна. Мэдээж хэрэг



азтаны маань шагнал манай Монгол базальт ХК-ийн хэрэгжүүлж буй төсөл болох хөрсгүй тариалалтын гидропоник төхөөрөмж байгаа юм. Энэхүү төхөөрөмж нь базальт чулуун хөвөн дээр өрхийн хэрэглээний ногоо, ургамал тариалах зориулалттай юм. Өнөөдрийн хуралд ирсэн хамгийн ахмад настай 2 эрхэмээр азтанг сугалуулья.

Санал хураах хугацаа дуусч хурлыг үргэлжлүүлэв.

Хурлын дарга П.Нямдорж: Энд байгаа хувьцаа эзэмшигч нар бүгд саналын хуудсаа өгч, саналыг тоолж дууссан байна. Санал хураалтын тухай тооллогын комиссын тогтоолыг танилцуулна уу хэмээн Тооллогын комиссын дарга Н.Сугарсүрэнг урьж байна.

Тооллогын комиссын дарга Т.Ууганцэцэг: Тооллогын комиссын тогтоолыг танилцуулъя.

2026 оны 04 сарын 30-ны өдөр Дугаар №2,

Компаний тухай хуулийн 72 дугаар зүйлийн 72.1.1, 72.1.3 дах заалт, 2026 оны 4 дүгээр сарын 30-ний өдрийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын тооллогын комиссын актыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. “Монгол базальт” ХК-ийн 2025 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаарх Төлөөлөн удирдах зөвлөлийн дүгнэлтийг хэлэлцэн батлах, эсэх: нийт _____ хувьцаа эзэмшигч санал өгснөөс зөвшөөрсөн- 35, түдгэлзсэн- 2, татгалзсан- 0 буюу санал хураалтын дүнгээр санал өгсөн хувьцаа эзэмшигчдийн 94.6 хувь нь зөвшөөрсөн байх тул шийдвэр хүчинтэйд тооцсугай.

2. Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүдийн сонгох Кумулятив аргаар хураасан санал хураалт нь Компанийн тухай хуульд заасан шаардлагыг хангаж, санал өгсөн хувьцаа эзэмшигчид СЗХ-ны баталсан “Санал хураах кумулятив аргыг хэрэглэр журам”-ын дагуу оролцсон байх тул санал хураалтыг хүчинтэйд тооцсугай.

Тооллогын комиссын дарга Н.Сугарсүрэн

Шийдвэрлэсэн нь:

Хурлын дарга П.Нямдорж: За тооллогын комиссын тогтоолоор санал хураалт хүчинтэйд тооцсон тул өнөөдрийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлаас гарах тогтоолын төслийг танилцуулж байна.

1. Монгол базальт ХК-ийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын тогтоол 2026 оны 04 сарын 30-ны өдөр, Дугаар 1 Компанийн 2025 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайланд Төлөөлөн удирдах зөвлөлийн өгсөн дүгнэлтийг батлах тухай
Компанийн тухай хуулийн 62-р зүйлийн 62.1.9-д заалт, “Монгол Базальт” ХК-ийн дүрмийн 6.1.5.11-д заалт, 2026 оны 04 сарын 30-ны өдрийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын тооллогын комиссын дүнг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. “Монгол Базальт” ХК-ийн 2025 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайланд Төлөөлөн удирдах зөвлөлөөс гаргасан дүгнэлтийг баталсугай.

Хурлын дарга П.Нямдорж

2. Монгол базальт ХК-ийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын тогтоол 2026 оны 04 сарын 30-ны өдөр, Дугаар 2, Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүдийг сонгох тухай

Компанийн тухай хуулийн 62-р зүйлийн 62.1.7-д заалт, “Монгол Базальт” ХК-ийн дүрмийн 6.1.5.9-д заалт, 2026 оны 04 сарын 30-ны өдрийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын тооллогын комиссын дүнг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. “Монгол Базальт” ХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн ердийн гишүүнээр

1. Лхагважавын Ариунболд
2. Галбадрахын Ганзориг
3. Бадрахын Шаравсамбуу
4. Пүрэвбанзрагчийн Сайнбилэг
5. Ариунболдын Энхгэрэл

6. Хан Гю Бунг нарыг тус тус сонгосугай.

2. Төлөөлөн удирдах зөвлөлийн хараат бус гишүүнээр

1. Шаравсамбуугийн Энхтөр
2. Чансаагийн Зоригтбаатар
3. Пүрэвсүхийн Нямдорж нарыг тус тус сонгосугай.

3. Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүд үйл ажиллагаандаа Компанийн тухай хууль, Үнэт цаасны зах зээлийн тухай хууль, Компанийн засаглалын кодекс, Компанийн дүрэм болон бусад хууль тогтоомжийг баримтлан компанийн эрх ашгийг дээдлэн ажиллахыг үүрэг болгосугай.

Хурлын дарга П.Нямдорж гэжээ.

Хурлын дарга П.Нямдорж: За өнөөдөр цаг заваа зарцуулж, компанийнхаа хувьцаа эзэмшигчдийн хуралд биечлэн оролцсон та бүхэндээ маш их баярлалаа. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурал дууссан болохыг мэдэгдэж байна.

ТЭМДЭГЛЭЛ ХОТӨЛСӨН: ТУЗ-ийн нарийн бичгийн дарга



Танилцсан: Хурлын дарга

О.Билгүүн
П.Нямдорж

О.Билгүүн

П.Нямдорж